



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 08 өдөр

Дугаар A/29

Улаанбаатар хот

“Монгол хүүхдүүд” баярын нэгдсэн арга
хэмжээнд Сити тур төслийг сурталчлах
тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/530 дугаар захирамж, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулагдах “Монгол хүүхдүүд” баярын нэгдсэн арга хэмжээнд “Сити тур” төслийг сурталчлан оролцсугай.

2. Арга хэмжээг зохион байгуулах төсвийг хавсралтаар баталж шаардагдах 400.000 /дөрвөн зуун мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Уянга/-д зөвшөөрсүгэй.


3. Арга хэмжээ зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс /В.Батчимэг/-т даалгасугай.

ДАРГА *D. Batsukh* Д.БАТСҮХ



1159509162

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2023 оны 06 сарын 08 өдрийн
А/29 дугаар тушаалын хавсралт



“МОНГОЛ ХҮҮХДҮҮД БАЯРЫН НЭГДСЭН
АРГА ХЭМЖЭЭНД СИТИ ТУР ТӨСЛИЙГ СУРТАЛЧЛАХ ТӨСВИЙН ЗАДАРГАА

2023 оны 06 дугаар сарын 6-ны өдөр

Улаанбаатар хот

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	“Зөв цэвэр аялъя” сургалт зохион байгуулах	1	400 000	400 000
Нийт				400 000

--- оОо ---